

18. Лавлагаа нэгтгэл

Лавлагаа модуль нь дээд боловсрол төгсөгчдийн дипломын лавлагаа, элсэлтийн ерөнхий шалгалтын лавлагааны жагсаалт, тайлан, хянах самбар гэсэн дэд хэсгүүдээс бүрдэнэ.

Лавлагаа модульд дээд боловсролын диплом, бакалавр, магистр, докторын боловсрол эзэмшиж боловсролын зэрэг авсан төгсөгчдийн дипломын мэдээллийг сургууль, хичээлийн жил бүрээр нэмж оруулан мэдээллийн бааз бүрдүүлэх шийдлийг боловсруулж хөгжүүлсэн ба дипломын мэдээллийг сургууль, боловсролын зэрэг, төгссөн он, мэргэжлийн чиглэлээр харах, хайх, түүнийг удирдаж ашиглана.

Дипломын лавлагаа хэсэгт диплом бүрээр төгсөгчийн овог, нэр, регистр, дипломын дугаар, төгссөн сургууль, мэргэжлийн чиглэл, индекс, сургалтын хөтөлбөр, голч оноо, суралцсан жил, судалсан сургалтын агуулгын мэдээллийг багтаасан ба улсын хэмжээнд мэргэжлийн чиглэл, төгссөн он, сургууль зэрэг мэдээллээр нарийвчлан бүртгэж байгаа тул анализ хийж, шийдвэр гаргалтад ашиглах бүрэн боломжтой.

Лавлагаа модульд дээд боловсролын элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой элсэлтийн ерөнхий шалгалтын лавлагаа хэсгийг нэмж оруулсан ба жил, жилээр элсэлтийн ерөнхий шалгалтын мэдээллийн баазыг БСШУСЯ-ны харьяа байгууллага болох Боловсролын үнэлгээний төвөөс авч системд оруулан шалгуулагчдын нэр, регистр, шалгалт, шалгалт өгсөн он, шалгалтын оноо зэргийг харах боломжтойгоор боловсруулсан.

Лавлагааны үндсэн мэдээлэл

№	Талбар	Тайлбар	Жишээ
1.	Хүн сонгох- РД оруулж хайлт хийнэ. Хүний мэдээллийг УБЕГ-аас татан авч байгаа тул овог, нэр бөглөгдөн гарч ирнэ.		
1.	Шалтгаан	Лавлагаанд мэдээлэл оруулах шалтгааныг сонгоно.	Шинээр үүсгэх
2.	Огноо	Лавлагаа нэмсэн огноог оруулна.	2019-06-17
Боловсролын мэдээлэл- Эзэмшсэн боловсролын мэдээллийг дэлгэрэнгүйгээр бүртгэнэ.			
1.	Сургалтын байгууллага	Суралцаж төгссөн сургалтын байгууллагын жагсаалтаас сонгоно.	МУИС
2.	Сургууль	Салбар, бүрэлдэхүүн сургуулиас сонгоно.	Бизнесийн сургууль
3.	Боловсролын түвшин	Суралцаж төгссөн бакалавр, магистр, доктор гэсэн боловсролын түвшнээс сонгоно.	Бакалавр
4.	Мэргэжлийн чиглэл	Суралцаж төгссөн мэргэжлийн чиглэлээс сонгоно. Сонгосон боловсролын түвшнээс хамаарч харгалзах мэргэжлийн чиглэлийг сонгох боломжтой байна.	011101 - Боловсрол судлал
5.	Боловсролын зэрэг	Боловсролын түвшний дагуу олгосон боловсролын зэргийг	Бакалаврын зэрэг

		сонгоно.	
6.	Сургалтын хэлбэр	Сонгогдсон мэргэжлийн чиглэлээс шалтгаалж өдөр, орой, эчнээ гэсэн сонголт байна.	Өдөр
7.	Сургалтын ачаалал	Сонгон суралцсан хөтөлбөрөөс хамаарч сургалтын ачаалалыг сонгоно.	Бүтэн цагийн
8.	Төлөв	Олгогдсон, цуцлагдсан, хүчингүй болгосон гэсэн төлөвөөр удирдана. Дипломны мэдээлэл нэмэхдээ олгогдсон төлөвөөр, буруу хүн дээр дугаар олгоод төгсгөсөн бол цуцлагдсан төлөвөөр, дипломын мэдээлэл албан ёсоор хүчингүй болгосон тушаал гарсан бол шийдвэрт үндэслэн хүчингүй болгосон гэсэн төлөвөөр сонгоно.	Олгогдсон.
Баримт бичиг- Тухайн оюутны диплом дээрх мэдээллийг дэлгэрэнгүй бүртгэнэ.			
1.	Дипломын дугаар	Тухайн оюутан дээр олгосон дипломын дугаарыг бичнэ.	D202000000
2.	Голч	Нийт суралцсан хугацааны сургалтын агуулгын голч дүнг бичнэ.	2,8
3.	Тушаалын дугаар	Диплом олгосон тушаалын дугаарыг бичнэ.	A/3
4.	Хөтөлбөрийн код	Суралцсан хөтөлбөрийн кодыг бичнэ.	23
5.	Хөтөлбөрийн нэр	Сургууль дээр хэрэгждэг хөтөлбөрийн үндсэн нэрийг оруулна.	Боловсрол судлал - Өдөр
6.	Хөтөлбөрийн хугацаа	Хөтөлбөрийн сургалтын хугацааг бичнэ.	4
7.	Элссэн хичээлийн жил	Элссэн суралцсан хичээлийн жилийг сонгоно.	2016
8.	Элссэн улирал	Элсэн суралцсан улирлыг сонгоно.	1-р семестр
9.	Олгосон хичээлийн жил	Олгосон хичээлийн жилийг сонгоно.	2020
10.	Олгосон улирал	Олгосон улирлыг сонгоно.	2 семестр
11.	Олгосон огноо	Диплом дээрх олгосон огноог бичнэ.	2020-05-10